БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## БАЯНЦАГААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД: БНА-2021/74/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424, 99442140

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429

Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 11
3.Аудитын тайлан ..... 12
3.1. Ерөнхий зүйл ..... 12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ..... 12
3.4. Материаллаг байдал ..... 13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 14
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 17
3.9. Аудитын илрүүлэлт ..... 17
Залруулсан алдаа ..... 17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 17
Аудитын зөвлөмж ..... 17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 17
4. Менежментийн захидал ..... 18
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 19

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 2/161

танай ____________ -ны № ____________ -т

БАЯНЦАГААН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.НАНДИНЦЭЦЭГ ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **71,433,748.73** | **98,005,850.64** |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 9,950,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 9,950,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 9,950,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 71,433,748.73 | 88,055,850.64 |
| **351** | **Түүхий эд материал** | 24,384,452.00 | 26,495,677.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 24,384,452.00 | 23,866,677.00 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 2,629,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 46,029,296.73 | 61,560,173.64 |
| 35420 | Аж ахуйн материал | 28,043,550.00 | 40,000,950.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,985,746.73 | 21,559,223.64 |
| 35600 | Мал амьтад | 1,020,000.00 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,759,421,562.97** | **1,688,185,478.88** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,759,421,562.97 | 1,688,185,478.88 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,726,218,562.97 | 1,655,051,228.92 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,643,354,259.00 | 1,643,354,259.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -62,581,313.52 | -126,490,457.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 227,035,296.60 | 245,693,789.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -163,612,530.11 | -185,245,158.27 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 115,193,641.05 | 119,597,277.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -51,923,572.80 | -64,075,997.80 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 16,452,449.00 | 16,452,449.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -10,873,532.39 | -10,899,199.07 |
| 39217 | Ном | 13,173,866.14 | 16,664,266.14 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 33,203,000.00 | 33,134,249.96 |
| 39301 | Програм хангамж | 1,455,000.00 | 955,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,180,000.00 | -748,750.04 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,928,000.00 | 32,928,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,830,855,311.70** | **1,786,191,329.52** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **16,408,328.00** | **10,077,225.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 16,408,328.00 | 10,077,225.00 |
| **413** | **Өглөг** | 16,408,328.00 | 10,077,225.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 10,077,225.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 16,408,328.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 16,408,328.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,814,446,983.70** | **1,776,114,104.52** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,814,446,983.70 | 1,776,114,104.52 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 413,542,036.70 | 413,542,036.70 |
| 51101 | Өмч: - төрийн | 413,542,036.70 | 413,542,036.70 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 64,143,664.70 | 25,810,785.52 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 64,143,664.70 | 64,143,664.70 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -38,332,879.18 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,336,761,282.30 | 1,336,761,282.30 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,830,855,311.70** | **1,786,191,329.52** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,391,433,829.00** | **1,330,810,340.22** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **300,825,817.00** | **10,787,970.22** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 300,825,817.00 | 10,787,970.22 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 300,825,817.00 | 10,787,970.22 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,800.00 | 377,100.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 300,809,017.00 | 10,410,870.22 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **122,384,612.00** | **214,696,170.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 968,223,400.00 | 1,105,326,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,857,100.00 | 92,357,370.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,276,100.00 | 92,357,370.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 581,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 109,823,800.00 | 122,338,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 109,823,800.00 | 122,338,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 7,703,712.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 7,703,712.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,124,391,612.84** | **1,369,143,219.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,124,391,612.84** | **1,369,143,219.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,068,675,192.14 | 1,205,658,502.44 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 704,075,216.30 | 817,849,413.04 |
| 210101 | Үндсэн цалин | 529,965,809.30 | 586,489,773.78 |
| 210102 | Нэмэгдэл | 85,854,014.00 | 129,398,358.63 |
| 210104 | Урамшуулал | 88,255,393.00 | 101,961,280.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 90,822,133.00 | 103,762,774.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,956,982.00 | 74,582,249.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,989,631.00 | 8,297,348.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,033,800.00 | 6,123,425.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,257,020.00 | 1,529,909.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,584,700.00 | 13,229,843.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 103,323,800.00 | 117,425,138.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,294,344.00 | 4,974,319.00 |
| 210302 | Түлш, халаалт | 96,271,456.00 | 111,692,819.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 758,000.00 | 758,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,337,870.00 | 22,373,279.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,492,600.00 | 2,228,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,387,470.00 | 3,716,640.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,071,400.00 | 1,352,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 258,400.00 | 264,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 159,400.00 | 779,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,968,600.00 | 3,544,200.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 10,487,939.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 32,123,340.00 | 25,322,550.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 631,500.00 | 872,450.00 |
| 210502 | Хоол, хүнс | 31,347,640.00 | 24,450,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 144,200.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,518,328.00 | 7,270,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,518,328.00 | 7,270,000.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,990,000.00 | 1,978,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,990,000.00 | 1,978,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 822,800.00 | 5,539,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 422,800.00 | 5,089,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 100,661,704.84 | 104,137,748.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,799,190.00 | 5,234,935.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,368,750.00 | 1,114,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 91,493,764.84 | 97,788,613.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 55,716,420.70 | 163,484,716.96 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 43,111,936.00 | 102,639,244.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 7,703,712.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,420,590.00 | 15,844,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 75,763,762.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 2,563,800.00 | 9,391,482.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,423,834.00 | 1,639,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,712,300.00 | 5,249,088.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,920,562.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,892,184.70 | 55,596,384.96 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,892,184.70 | 55,596,384.96 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **267,042,216.16** | **-38,332,879.18** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 44,229,235.48 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 44,229,235.48 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -44,229,235.48 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **222,812,980.68** | **-38,332,879.18** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,090,624,812.00** | **1,320,399,470.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **16,800.00** | **377,100.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 16,800.00 | 377,100.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 16,800.00 | 377,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,800.00 | 377,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,090,608,012.00** | **1,320,022,370.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 968,223,400.00 | 1,105,326,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,857,100.00 | 92,357,370.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,276,100.00 | 92,357,370.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 581,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 109,823,800.00 | 122,338,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 109,823,800.00 | 122,338,800.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 7,703,712.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 7,703,712.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,090,624,812.00** | **1,320,399,470.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,090,624,812.00** | **1,320,399,470.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,034,908,391.30** | **1,156,914,753.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 704,087,908.30 | 807,772,188.04 |
| 210101 | Үндсэн цалин | 529,978,501.30 | 576,412,548.78 |
| 210102 | Нэмэгдэл | 85,854,014.00 | 129,398,358.63 |
| 210104 | Урамшуулал | 88,255,393.00 | 101,961,280.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 90,822,133.00 | 103,762,774.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,593,185.00 | 74,582,249.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,352,148.00 | 8,297,348.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,033,800.00 | 6,123,425.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,258,300.00 | 1,529,909.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,584,700.00 | 13,229,843.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 103,323,800.00 | 117,425,138.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,294,344.00 | 4,974,319.00 |
| 210302 | Түлш, халаалт | 96,271,456.00 | 111,692,819.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 758,000.00 | 758,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,630,270.00 | 16,565,740.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,443,600.00 | 2,228,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,387,470.00 | 3,716,640.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,071,400.00 | 1,352,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,599,800.00 | 3,455,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 159,400.00 | 779,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,968,600.00 | 5,034,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 33,438,540.00 | 39,391,450.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 631,500.00 | 3,513,050.00 |
| 210502 | Хоол, хүнс | 31,347,640.00 | 24,450,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,459,400.00 | 11,428,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 64,200,000.00 | 31,078,328.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 7,400,000.00 |
| 210602 | Тавилга | 25,600,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 38,600,000.00 | 23,678,328.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,990,000.00 | 1,978,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,990,000.00 | 1,978,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,678,800.00 | 5,574,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,278,800.00 | 5,124,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,736,940.00 | 33,366,535.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,999,190.00 | 8,099,035.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,737,750.00 | 25,267,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **55,716,420.70** | **163,484,716.96** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 43,111,936.00 | 102,639,244.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 7,703,712.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,420,590.00 | 15,844,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 75,763,762.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 2,563,800.00 | 9,391,482.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,423,834.00 | 1,639,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 1,920,562.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,920,562.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 12,604,484.70 | 58,924,910.96 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,892,184.70 | 55,596,384.96 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,336,761,282.30** | **64,143,664.70** | **00.00** | 1,814,446,983.70 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,336,761,282.30** | **64,143,664.70** | **00.00** | 1,814,446,983.70 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -38,332,879.18 | 00.00 | -38,332,879.18 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,336,761,282.30** | **25,810,785.52** | **00.00** | 1,776,114,104.52 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,228,665,000.00 | 1,170,525,153.04 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,228,665,000.00 | 1,170,525,153.04 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,206,298,500.00 | 1,153,041,153.04 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 834,484,600.00 | 807,772,188.04 |
| 210101 | Үндсэн цалин | 591,802,700.00 | 576,412,548.78 |
| 210102 | Нэмэгдэл | 131,041,100.00 | 129,398,358.63 |
| 210104 | Урамшуулал | 111,640,800.00 | 101,961,280.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 115,808,800.00 | 103,762,774.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 82,265,600.00 | 74,582,249.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,385,800.00 | 8,297,348.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,708,600.00 | 6,123,425.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,677,100.00 | 1,529,909.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,771,700.00 | 13,229,843.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 119,338,800.00 | 117,425,138.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,871,700.00 | 4,974,319.00 |
| 210302 | Түлш, халаалт | 112,709,100.00 | 111,692,819.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 758,000.00 | 758,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,592,400.00 | 16,565,740.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,228,300.00 | 2,228,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,718,000.00 | 3,716,640.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,376,700.00 | 1,352,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,455,000.00 | 3,455,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 780,000.00 | 779,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,034,400.00 | 5,034,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 51,900,500.00 | 39,391,450.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,513,100.00 | 3,513,050.00 |
| 210502 | Хоол, хүнс | 36,959,100.00 | 24,450,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 11,428,300.00 | 11,428,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 31,085,300.00 | 31,078,328.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,400,000.00 | 7,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 23,685,300.00 | 23,678,328.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,983,900.00 | 1,978,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,983,900.00 | 1,978,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,704,200.00 | 1,701,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,254,200.00 | 1,251,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33400000.00 | 33366535.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,100,000.00 | 8,099,035.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 25,300,000.00 | 25,267,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22366500.00 | 17484000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 22,366,500.00 | 17,484,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,727,000.00 | 15,844,500.00 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,639,500.00 | 1,639,500.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,228,665,000.00 | 1,170,525,153.04 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,105,326,200.00 | 1,049,729,815.04 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,105,326,200.00 | 1,049,729,815.04 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 122,338,800.00 | 120,418,238.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 122,338,800.00 | 120,418,238.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 377,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 377,100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 69.00 | 69.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 47.00 | 47.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 21.00 | 21.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **85,884,044.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **85,884,044.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 3,292,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 3,292,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 3,292,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **0.00** | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **0.00** | **82,591,444.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **0.00** | **82,591,444.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 75,763,762.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 6,827,682.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **0.00** | **85,968,489.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0.00** | **85,968,489.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 85,968,489.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | **0.00** | **0.00** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал С.Нандинцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд Төсвийн гүйцэтгэл, өр, авлага, холбоотой, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 13-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг Боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны төсөвт дотоод хяналт болон шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийгдээгүй байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 1369143,2 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 27382,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг багасгах шаардлага гараагүй.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1786191,3 мянган төгрөг болж өмнөх оноос 44664,0 мянган төгрөгөөр буюу 2,4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 97288,6 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол авлага 9950,0 мянга, бараа материал 16622,1 мянга, үндсэн хөрөнгө 26052,5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 71,433.7 | 98,005.9 | 26,572.1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 9,950.0 | 9,950.0 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 71,433.7 | 88,055.9 | 16,622.1 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,759,421.6 | 1,688,185.5 | (71,236.1) |
| Үндсэн хөрөнгө | 2,049,592.5 | 2,075,645.0 | 26,052.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (290,170.9) | (387,459.6) | (97,288.6) |
| **Нийт хөрөнгө** | 1,830,855.3 | 1,786,191.3 | (44,664.0) |
| Өр төлбөр | 16,408.3 | 10,077.2 | (6,331.1) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,814,447.0 | 1,776,114.1 | (38,332.9) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,830,855.3 | 1,786,191.3 | (44,664.0) |

Тухайн байгууллага нь өмнөх онд авлагагүй байсан бол тайлант онд 9950,0 мянган төгрөгийн авлагатай байна. Авлага өссөн шалтгаан нь "Санко Маркетинг Монголиа" ХХК-аас 2020.12.18-нд ухаалаг самбар худалдан авахаар гэрээ байгуулж оны эцэст тухайн ухаалаг самбар ирээгүйгээс 9950,0 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 88055,9 мянган төгрөг болж өмнөх оноос 16622,1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд аж ахуйн материал 28043,6 мянган төгрөгөөс 40001,0 мянган төгрөг болж өссөн бөгөөд тус дансанд гол нөлөө үзүүлсэн

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

нь 2020 онд 7000,0 мянган төгрөгийн үнэ бүхий 100 ширхэг матрас бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны өмнөх оны үлдэгдэл 2049592,2 мянган төгрөг байсан бол тайлант оны эцэст 2075645,0 мянган төгрөг болж 26052,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант хугацаанд 18658,5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3490,4 мянган төгрөгийн ном, 4403,6 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан нь гол нөлөө үзүүлж байна.

Засгийн газрын оролцоо дансны өмнөх оны үлдэгдэл 1336761,3 мянган төгрөг байсан бол тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх онд 1391433,8 мянган төгрөг байсан бол тайлант онд 1330810,3 мянган төгрөг болж 60623,5 мянган төгрөгөөр буюу 4,4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт нь 968223,4 мянган төгрөгөөс 1105326,2 мянган төгрөг болж 137102,8 мянга, Нэмэлт санхүүжилтийн орлого 87500,3 мянган төгрөгөөр өссөн байна. Харин нийтлэг татварын бус орлого 290037,8 мянган төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлж байна.

Нийт зардал өмнөх онд 1124391,6 мянган төгрөг байсан бол тайлант онд 1369143,2 мянган төгрөг болж 244751,6 мянган төгрөгөөр буюу 21,7 хувиар өссөн байна. Энэ нь тайлант хугацаанд цалингийн зардал өмнөх оноос 113774,2 ажил олгогчоос төлөх ЭМНДШ 12940,6 мянга Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 75763,8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 14101,3 мянга, бараа материал акталсны зардал 10487,9 мянган төгрөгөөр өссөн нь материаллаг дүнг эзэлж байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1303421,9 мянган төгрөгөөр төсөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 10760,6 мянган төгрөгөөр бууруулж 1292661.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүргүүлсэн саналаас гол нэмэгдэн зардал нь цалингийн зардлаас 50783,3 мянга, хангамж материалын зардлаас 10604,5 мянга, томилолтын зардлаас 4666,1 мянга, урсгал шилжүүлгээс 3389,4 мянган төгрөг хасаж, ажил олгогчоос олгох ЭМНДШ-д 2037,9 мянга, нормативт зардалд 31490,2 мянга, эд хогшил худалдан авах зардалд 14677,0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 10068,8 мянган төгрөгийг нэмж баталжээ.

Харин оны дундуур нийт 63999,0 мянган төгрөг хассан бөгөөд үүнд тогтмол зардлыг 21606,6 мянга, нормативт зардлыг 45916,1 мянга, урсгал шилжүүлгийг 32260,5 мянган төгрөгөөр хасаж, харин ЭМНДШ-ийг 2600,0 мянга, хангамж

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

материалын зардлыг 4775,0 мянга, эд хогшил урсгал засварын зардлыг 16408,0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7арга хэмжээг санхүүжүүлэхээр 1228665,0 мянган төгрөгийн төсөв баталсныг улсын төсвөөс 1227665,0 мянга, өөрийн орлогоор 1000,0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилт бүрэн авч төсөвт байгууллагын өөрийн орлогыг 377,1 мянган төгрөгийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 1170525,3 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 57516,9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1170525,3 мянган төгрөг буюу 95,3 хувьтай байгаа нь цалин хөлс 26717,4, ажил олгогчоос төлөх ЭМНДШ 12046,0 мянга, хоол хүнсний зардал 12509,0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

| Үзүүлэлт | | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| НИЙТ | | 1,228,665,000.00 | 1,170,525,253.04 | 58,139,746.96 | **95.27** |
| **ХӨТӨЛБӨР 71802-Ерөнхий боловсрол** | | 1,217,784,000.00 | 1,162,104,160.98 | 55,679,839.02 | **95.43** |
| **АРГА ХЭМЖЭЭ 80109- Тогтмол зардал** | | **122,338,800.00** | **120,418,238.00** | **1,920,562.00** | **98.43** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | | **122,338,800.00** | **120,418,238.00** | **1,920,562.00** | **98.43** |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 122,338,800.00 | 120,418,238.00 | 1,920,562.00 | **98.43** |
| **АРГА ХЭМЖЭЭ 80802 -Ажил олгогчоос олгох тэтгэмж** | | **1,639,500.00** | **1,639,500.00** | 0.00 | **100.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шаг урамшуулал | 1,639,500.00 | 1,639,500.00 | 0.00 | **100.00** |
| **АРГА ХЭМЖЭЭ 81801- Үдийн цай** | | **20,727,000.00** | **15,844,500.00** | 4,882,500.00 | **76.44** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэт, урам | 20,727,000.00 | 15,844,500.00 | 4,882,500.00 | **76.44** |
| **АРГА ХЭМЖЭЭ 81801- Дотуур байр** | | **124,672,300.00** | **105,380,248.98** | **19,292,051.02** | **84.53** |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 66,364,100.00 | 59,581,048.98 | 6,783,051.02 | **89.78** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 8,959,100.00 | 8,959,100.00 | 0.00 | **100.00** |
| Хангамж, бараа материалын зардал | | 949,200.00 | 949,200.00 | 0.00 | **100.00** |
| Нормативт зардал | | 47,179,500.00 | 34,670,500.00 | 12,509,000.00 | **73.49** |
| Эд хогшил, урсгал засварын зардал | | 1,220,400.00 | 1,220,400.00 | - | **100.00** |
| **АРГА ХЭМЖЭЭ 81834- Боловсролын стандарт сургалтын** | | **724,994,600.00** | **707,591,006.94** | **17,403,593.06** | **97.60** |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 575,003,100.00 | 569,546,438.94 | 5,456,661.06 | **99.05** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 80,778,900.00 | 68,878,555.00 | 11,900,345.00 | **85.27** |
| Хангамж, бараа материалын зардал | | 10,845,200.00 | 10,820,900.00 | 24,300.00 | **99.78** |
| Нормативт зардал | | 4,721,000.00 | 4,720,950.00 | 50.00 | **100.00** |
| Эд хогшил, урсгал засварын зардал | | 26,864,900.00 | 26,864,828.00 | 72.00 | **100.00** |
| Томилолт, зочны зардал | | 1,983,900.00 | 1,978,000.00 | 5,900.00 | **99.70** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 1,704,200.00 | 1,701,000.00 | 3,200.00 | **99.81** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 23,093,400.00 | 23,080,335.00 | 13,065.00 | **99.94** |
| **АРГА ХЭМЖЭЭ 81835-Сургалтын үйл ажиллагаа** | **223,411,800.00** | **211,230,667.06** | **12,181,132.94** | **94.55** |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 183,800,700.00 | 171,707,927.06 | 12,092,772.94 | **93.42** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 24,813,100.00 | 24,747,000.00 | 66,100.00 | **99.73** |
| Хангамж, бараа материалын зардал | 4,798,000.00 | 4,795,740.00 | 2,260.00 | **99.95** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 10,000,000.00 | 9,980,000.00 | 20,000.00 | **99.80** |
| **ХӨТӨЛБӨР 71806-Насан туршийн болон албан бус** | **10,881,000.00** | **8,421,092.06** | **2,459,907.94** | **77.39** |
| **АРГА ХЭМЖЭЭ 80101-Үндсэн үйл ажиллагаа** | **10,881,000.00** | **8,421,092.06** | **2,459,907.94** | **77.39** |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 9,316,700.00 | 6,936,773.06 | 2,379,926.94 | **74.46** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,257,700.00 | 1,178,119.00 | 79,581.00 | **93.67** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 306,600.00 | 306,200.00 | 400.00 | **99.87** |

## Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 3 төрлийн нийт 92357,4 мянган төгрөг орж ирсэн бөгөөд 89028,4 мянган төгрөгийг зарцуулан оны эцэст 3328,5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Дээрх 3 төрлийн санхүүжилтийг зориулалт тус бүрээр авч үзвэл:

мянган төгрөг

| № | Зориулалт | Санхүүжсэн дүн | Зарцуулсан | Буцаан төвлөрүүлсэн |
|---|---|---|---|---|
| 1 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж | 79092.3 | 75763.8 | 3328,5 |
| 2 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны 5 жилийн тэтгэмж | 9391.5 | 9391.5 | 0 |
| 3 | Түрээсийн сурах бичиг | 3873.6 | 3873.6 | 0 |
| | Нийт | 92357.4 | 89028.4 | 3328.5 |

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны сайтад 151 мэдээ мэдээлэхээс мэдээллийг бүрэн байршуулсан бөгөөд үүнээс 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | Бүтэн жил | 11 | 11 | 8 | 3 | 0 |
| **2** | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 |
| **3** | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | 0 |
| **4** | Сар бүр | 3 | 36 | 27 | 9 | 0 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 88 | 8 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 130 | 21 | 0 |

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд сахилгын шийтгэл ногдуулсан 2 багшид 917,0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байсанд төлбөрийн акт тогтоосныг 2020.03.25-нд барагдуулсан.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23027,2 мянган төгрөгийн 4 төрлийн зөрчил илэрсэнд , зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар залруулга хийгдээгүй.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн асуудал байхгүй байна.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 2 төрлийн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Аудитаар анхаарал татах бусад асуудал байхгүй байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

1.1. Илрүүлэлт:

1.1.1. "Санко Маркетинг Монголиа" ХХК-ийн нийлүүлэгдэх 9950,0 мянган төгрөгийн үнэ бүхий ухаалаг самбар нь биетээр ирээгүй авлага үүсгэсэн байна.

1.1.2.

1.1.3. Цалинг давтан тооцоолоход 10077,2 мянган төгрөгийн НДШ-ийн өглөгтэй гарсан бөгөөд энэ нь 12-р сард ажил олгогчоос төлөх шимтгэлийг шилжүүлээгүйтэй холбоотой байна.

1.2. Эрсдэл:

1.2.1. Хөрөнгө ирэхгүйгээс найдваргүй авлага үүсэх

1.2.2. Дараа жилийн төсөвт ачаалал үүсэх

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

2. **ТӨСӨВ,ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

2.1. Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн журналаас эдийн засгийн ангиллаар зардлын ангилал тус бүрд шинжилгээ хийхэд хичээл практикийн зардлаас 6 насны ширээ 3000,0 мянган төгрөгөөр бэлтгэсэн байна.

2.2. Эрсдэл:

Хууль журам зөрчигдөх

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг байдлыг зогсоож, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР: Б.АЗБАЯР 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ 2021.02.25

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДУГНЭЛТ

## 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Баянцагаан сумын ЕБС-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 он | | | БНА-2021/74/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | "Санко Маркетинг Монголиа" ХХК-ийн нийлүүлэгдэх 9950,0 мянган төгрөгийн үнэ бүхий ухаалаг самбар нь биетээр авлага үүсгэсэн байна. | 9950,0 | Зөвлөмж өгөх. | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | С.Нандинцэцэг, Г.Наранчимэг |
| 2 | Цалинг давтан тооцоолоход 10077,2 мянган төгрөгийн НДШ-ийн өглөгтэй гарсан бөгөөд энэ нь 12-р сард ажил олгогчоос төлөх шимтгэлийг шилжүүлээгүйтэй холбоотой байна. | 10077.2 | Зөвлөмж өгөх. | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | С.Нандинцэцэг, Г.Наранчимэг |
| 3 | Мөнгөн хөрөнгийн журналаас эдийн засгийн ангиллаар зардлын ангилал тус бүрд шинжилгээ хийхэд хичээл практикийн зардлаас 6 насны ширээ 3000,0 мянган төгрөгөөр бэлтгэсэн байна. | 3000.0 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | С.Нандинцэцэг, Г.Наранчимэг |
| 4 | Шилэн дансны сайтад 151 мэдээ мэдээлэхээс мэдээллийг бүрэн байршуулсан бөгөөд үүнээс 89360,7 мянган төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 0 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | С.Нандинцэцэг, Г.Наранчимэг |
| **ДҮН** | | **23027.2** | | | |

- oOo -